



МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2017 оны 6 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар
хот

Барилга байгууламжийн гал
түймрийн эрсдэлийн зэргийн
ангилал батлах тухай

Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “Барилга байгууламжийн гал түймрийн эрсдэлийн зэргийн ангилал”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү ангилалын дагуу гал түймрийн онц аюултай болон гал түймрийн аюултай нэг, хоёрдугаар зэргийн барилга байгууламжийн жагсаалтыг гаргаж батлахыг Онцгой байдлын ерөнхий газар /бригадын генерал Т.Бадрал/-т үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2008 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 267 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Шадар сайд

У.ХҮРЭЛСҮХ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЛ ТҮЙМРИЙН
ЭРСДЭЛИЙН ЗЭРГИЙН АНГИЛАЛ

Гал түймрийн эрсдэлийн зэрэг	Хамаарах барилга, байгууламж
Гал түймрийн онц аюултай	<ul style="list-style-type: none">- Галын болон тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт бодис, хялбар авалцан асах шингэн, тоосжилт ихтэй үйлдвэр, байгалийн болон шингэрүүлсэн хий ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа барилга, байгууламж, үйлдвэрлэл, агуулах,- газрын тосны бүтээгдэхүүнийг олборлох, үйлдвэрлэх, хадгалах объектууд,- шатахуун түгээх станц, автомашинд хий түгээх станц,- тэсэрч шатах галын аюулын А, Б ангиллын өрөө, тасалгаа, агуулах,- эрчим хүчний үйлдвэр, цахилгаан түгээх байгууламжууд,- 80000 м³ дээш эзлэхүүнтэй үйлдвэр,- улсын нөөцийн объект,- үндэсний төв архив,- үндэсний номын сан,- байгалийн болон түүхийн музей,- 28 м-ээс дээш өндөртэй барилга, байгууламжууд.
Гал түймрийн аюултай 1 дүгээр	<p>Гал түймрийн онц аюултай зэрэгт хамаарахгүй цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх объект,</p> <p>Үүргийн галын аюулын Ф3.4 (Поликлиник ба амбулатори), Ф4.2 (Их дээд сургууль, мэргэжил дээшлүүлэх байгууллагууд), Ф4.3 (Засаг захиргаа, удирдлага, зураг төслийн болон хэвлэл мэдээлэл, шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний байгууллага, банк) ангийн 15-28 м хүртэлх өндөртэй барилга, байгууламж,</p> <p>Үүргийн галын аюулын Ф1.1 ангийн (Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага, ахмадуудын асрамжийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай зориулалтын байр, сургуулийн хүүхдийн дотуур байр, хүүхдийн байгууллага)</p> <ul style="list-style-type: none">- 20-оос дээш ортой эмнэлэг, <p>Үүргийн галын аюулын Ф1.2 ангийн (Зочид буудал, нийтийн байр, нийтийн зориулалттай амралтын газар, рашаан сувилал, түр буудал, аялал жуулчлалын газрын унтлагын байр)</p> <ul style="list-style-type: none">- 50-аас дээш ортой зочид буудал,- 10-аас дээш өрөөтэй нийтийн зориулалттай байр,- 50-аас дээш ортой амралтын газар, рашаан сувилал,

	<p>Үүргийн галын аюулын Ф2 ангийн (Үзвэр, үйлчилгээ, соёл гэгээрлийн албан байгууллага)</p> <ul style="list-style-type: none"> - 600-аас дээш суудалтай үзвэр үйлчилгээний газар, - орон нутгийн номын сан, <p>Үүргийн галын аюулын Ф3 ангийн (Нийтийн үйлдвэрлэл, үйлчилгээний газрууд)</p> <ul style="list-style-type: none"> - нэг дор 200-аас дээш хүнд үйлчилдэг төмөр замын буудал, - олон улсын болон орон нутгийн нисэх онгоцны буудал, - 10000 м²-аас дээш талбайтай худалдааны газар, - нэг дор 200-аас дээш хүнд үйлчлэх боломжтой худалдааны болон үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг барилга, байгууламж, - нэг дор 80-аас дээш хүнд үйлчлэх боломжтой нийтийн хоол, ресторан, цэнгээний газар <p>Үүргийн галын аюулын Ф4.1 ангийн (Сургууль, сургуулийн гадуурх сургалтын байр, тусгай дунд болон техник мэргэжлийн сургуулиуд)</p> <ul style="list-style-type: none"> - 640-өөс дээш суудалтай ерөнхий боловсролын болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, <p>Үүргийн галын аюулын Ф5 ангийн (Үйлдвэрийн ба агуулахын барилга байгууламж, өрөө тасалгаа)</p> <ul style="list-style-type: none"> - барилгын газар доорх болон 20-иос дээш авто машины зогсоолтой /битүү/ авто зогсоол, үйлчилгээний байгууламж, - хөнгөн үйлдвэр, - мод, модон эдлэлийн үйлдвэрлэл, - дизель станцын байгууламжууд, - өвсний фонд, - 15000-80000 м³ эзлэхүүнтэй үйлдвэр, - тэсэрч шатах галын аюулын В1-В4, Г ангиллын өрөө, тасалгаа, агуулах,
<p>Гал түймрийн аюултай 2 дугаар</p>	<p>Үүргийн галын аюулын Ф3.4 (Поликлиник ба амбулатори), Ф4.2 (Их дээд сургууль, мэргэжил дээшлүүлэх байгууллагууд), Ф4.3 (Засаг захиргаа, удирдлага, зураг төслийн болон хэвлэл мэдээлэл, шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний байгууллага, банк) ангийн 6-15 м хүртэлх өндөртэй барилга, байгууламж,</p> <p>Үүргийн галын аюулын Ф1.1 ангийн</p> <ul style="list-style-type: none"> - 10-20 хүртэлх ортой эмнэлэг, <p>Үүргийн галын аюулын Ф1.2 ангийн</p> <ul style="list-style-type: none"> - 20-50 хүртэлх ортой зочид буудал, - 10 хүртэлх өрөөтэй нийтийн зориулалттай байр, - 20-50 хүртэлх ортой амралтын газар, рашаан сувилал, <p>Үүргийн галын аюулын Ф2 ангийн</p> <ul style="list-style-type: none"> - 200-600 хүртэлх суудалтай үзвэр үйлчилгээний газар, - сургалт, эрдэм шинжилгээний номын сан, <p>Үүргийн галын аюулын Ф3 ангийн</p> <ul style="list-style-type: none"> - нэг дор 200 хүртэлх хүнд үйлчилдэг төмөр замын буудал,

	<ul style="list-style-type: none"> - 5000-10000 м² хүртэлх талбайтай худалдааны газар, - нэг дор 50-200 хүртэлх хүнд үйлчлэх боломжтой худалдааны болон үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг барилга байгууламж, - нэг дор 20-80 хүртэлх хүнд үйлчлэх боломжтой нийтийн хоол, ресторан, цэнгээний газар <p>Үүргийн галын аюулын Ф4.1 ангийн</p> <ul style="list-style-type: none"> - 280-640 хүртэлх суудалтай ерөнхий боловсролын болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, <p>Үүргийн галын аюулын Ф5 ангийн</p> <ul style="list-style-type: none"> - барилгын газар доорх болон 10-20 хүртэлх автомашины зогсоолтой /битүү/ авто зогсоол, үйлчилгээний байгууламж, - 5000-15000 м³ эзлэхүүнтэй үйлдвэр,
<p>Гал түймрийн аюултай 3 дугаар</p>	<p>Дээрх 3 төрлийн объектын ангилалд ороогүй бусад объектууд орно.</p>

---oOo---